

ХИЛИЙН ЦЭРГИЙН АНГИУДАД ЦАХИМ СУРГАЛТЫГ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМ

Б.Жавхлан

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа

Товч агуулга: Хил хамгаалах байгууллагын сургалтын үйл ажиллагааг орчин үеийн техникийн дэвшилттэй хослуулан явуулж, бие бүрэлдэхүүнийг давтан сургах, мэргэшүүлэх удирдлага, зохион байгуулалтын асуудалд ахиц гаргахад оршино.

Abstract: The purpose of the training is to combine the training activities of border guards with modern technical advances and to make progress in the management and organization of retraining of personnel.

Түлхүүр үгс: Хил хамгаалах байгууллага, сургалт, өнөөгийн байдал, цахим сургалт, удирдлага, зохион байгуулалт.

Keywords: Border protection organization, training, current situation, e-learning, management, organization.

Оршил

Хил хамгаалах байгууллагад ажиллаж байгаа цэргийн алба хаагч нь төрийн албаны тухай хуульд зааснаар **төрийн тусгай албан хаагч** “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх”¹, Монгол Улсын хилийн тухай хуульд зааснаар **Хилчин** “хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагч”², цэргийн албаны тухай хуульд зааснаар **цэргийн жинхэнэ албан хаагч** “Цэргийн байгууллагад цэргийн

албыг биеэр хааж байгаа Монгол Улсын иргэн”³ юм.

Хил хамгаалах байгууллагын алба хаагч /цаашид хилчин/ нь цэргийн болон Хууль сахиулах мэргэжлийн албыг хослуулан явуулах чадвар бүхий Монгол Улсын иргэн юм.

Хилчин нь хууль тогтоомжид заасан үүргээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд мэдлэг боловсролоо дээшлүүлэх, сурч боловсрох шаардлагатай болохыг дараах баримтуудаар нотолж болох юм. Үүнд:

-Эрх зүйн баримт бичгийн өөрчлөлт /Сүүлийн 5 жилийн байдлаар Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн

¹Төрийн албаны тухай хуулийн

²Монгол Улсын хилийн тухай хууль

³Цэргийн албаны тухай хууль

эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль/

-Албаны заавар, стандартын өөрчлөлт /Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт, Цэргийн биеийн тамирын заавар, Монгол Улсын Цэргийн дүрэм/

-Цэргийн мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэнд офицер, ахлагчийн анхны цол олгох /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 41 дүгээр зарлиг/

-Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл Цэргийн алба хаагчийн үүрэг 6.1.10 дахь заалт “Мэдлэг, мэргэшлийн түвшнээ ахиулж байх”-гэж тус тус хуульчилсан байна.

Хилчдийн хувьд ажлын чиг үүрэг, хууль тогтоомжоор тасралтгүй сурч боловсорч, мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх шаардлага тулгарч байна.

Нэг. Цахим сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага, боломж

“Цахим шилжилт хийхэд Мэдээлэл, харилцаа холбооны салбар болон бусад салбар хоорондын хамтын ажиллагаа чухал” Н.Учрал

Монгол улсад зайны сургалт анх интернэт сүлжээ орсон цагаас эхлэн нэвтэрч эхэлсэн гэж үзэж болно. Монгол Улсын анхны интернэт сүлжээ бий болж, 1996-1998 онд ерөнхий боловсролын сургуулиудад Япон, Солонгос улсуудын хөрөнгө оруулалттай интернэт танхимууд байгуулагдаж, интернэт сүлжээнд

хайлт хийх боломж бүрдсэн цагаас эхлэн цахим сургалт, зайны сургалтын гэсэн ойлголтууд бий болсон гэж үзэж болно.

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 14 дүгээр тогтоолоор “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр”¹ баталсан. Уг тогтоолын үндэслэл хэсэгт “Шинэ зууны боловсролын нэг гол шинж бол нээлттэй сургалт, зайны сургалтын арга хэлбэр өргөжиж байгаа явдал мөн. Боловсролын тухай хуульд хөгжлийн шинэ нөхцөл байдлыг харгалзан боловсролын зорилгыг иргэдийнхээ бие даан сурч, амьдрах чадвартай болгоход нь үйлчлэх чиглэлээр шинэчлэн тодорхойлсон билээ. Боловсролын хэрэгцээг орон зай, цаг хугацаанаас төдийлөн шалтгаалахгүйгээр уян хатан, олон хувилбартай, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар хангах тогтолцоо бий болгох нь чухал байна”, зорилгод “Энэхүү хөтөлбөрийн зорилго нь албан болон албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, хүн амд насан туршдаа суралцах бололцоо олгоход нь дэмжлэг үзүүлэх зайны сургалтын үндэсний тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэхэд оришиж байна” гэж дурдсан нь цахим сургалтын эрх зүйн үндэс болж байгаа юм.

Өнөөгийн нийгэмд Дэлхийн улс орнууд технологийн дэвшлээр өрсөлдөж интернэт сүлжээний хурд жил бүр сайжирч 2019 он гэхэд дэлхийн

¹Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 14 дүгээр тогтоол

“Цэргийн албаны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.10 дахь заалт

2 орон 5G сүлжээний хурдыг нэвтрүүлээд байна. Бүгд найрамдах хятад ард улсад холбооны сүлжээний 6G технологийг нэвтрүүлэхээ ч мөн зарлаад байна.

Энэхүү хөгжлийг дагаад бидний өдөр тутамдаа хэрэглэж буй гар утас, компьютер, зурагт өөрчлөгдөж, хүчин чадал, үзүүлэлт нь жил бүр сайжирч тааварлахын аргагүй технологийн боломжууд нэвтэрсээр байна.

Цахим сургалт нь нэг үгээр хэлбэл “МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ”-д суурилсан сургалт юм. Цахим сургалтын материалыг боловсруулах нь танхимын сургалтын материал боловсруулахаас үнэтэй, цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр их шаарддаг. Харин боловсруулсны дараа энэхүү сургалтын гол онцлог, давуу тал нь та өөрийн биеэр очиж, заавал цаг зав гарган багштайгаа уулзаж, лекц бичих, сонсох

гэх мэт механик ажиллагааг шаарддаггүй.

Электрон засаглал /E-Government/, электрон арилжаа /E-Commerce/, электрон сургалт /E-Learning/, электрон эмчилгээ /E-therapy/ зэрэг дэвшилтэд технологи, үйлчилгээнүүд бий болж мэдээлэл, мэдлэгийг асар богино хугацаанд хүлээн авах боломж бүрдсэн.

Тийм ч учраас цахим сургалт явуулах боломжуудыг судалж, байгууллагын сургалтын ажилд нэвтрүүлснээр цаг хугацаа, хөрөнгө, мөнгө хэмнэхээс гадна сургалтын өргөн хүрээг ашиглах бүрэн боломж бүрдэж байгаа юм.

Монгол Улсын хувьд нийслэл, аймгийн төвүүд 100 хувь, сум, суурин газруудын 94 хувь /17 сум шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй/ нь 4G /нэг секундэд 500 мб файл хуулах/ технологийн интернэт сүлжээнд холбогдсон байна

Цахим сургалтын давуу ба сул тал

Хүснэгт-1

Давуу тал	Сул тал
Ажилтнуудын хэрэгцээнд нийцэх	Интернэтийн хурд, технологийн хүчин чадал нөлөөлдөг
Тасралтгүй сурч хөгжих	Сургагч нараас шууд асууж, харилцан ярилцах боломж хязгаарлагдмал
Суралцах тэгш боломжийг олгох	Багаар хамтран ажиллах боломж бага
Танхимын сургалтын ачаалал багасах	Лаборатори, дадлага, дасгалын аргаар сургалт явуулах боломж бага
Онцгой нөхцөл байдал үүссэн үед ч сургалт явуулах боломжтой	Шавилан сурах, менторшипийн харилцаа үүсэх боломж хязгаарлагддаг
Сурах нөхцөл боломж хязгааргүй	
Сургагч нарын ачаалал буурч, өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдэх	

*Коронавирусийн дараах ертөнцөд өөрийгөө бэлдэх хамгийн сайн арга бол технологийн ур чадвар эзэмших юм.*¹

Дэлхийн нийтээр 2019 он гарсаар коронавирусын цар тахлын дэгдэлт нэмэгдэж, хил хамгаалах байгууллага байтугай Монгол Улсын хэмжээнд урьд өмнө байгаагүй ажлын нөхцөл, амьдралын хэв маяг явагдаж эхэлсэн.

Манай орны хувьд коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга замуудыг эртнээс амжилттай хэрэгжүүлж, төрийн байгууллагууд харьцангуй тогтвортой ажиллаж байсан боловч, 2020 оны 11 дүгээр сараас халдварыг дотооддоо алдсанаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж хорио цээрийн дэглэм тогтоож, бүх байгууллагууд цахимаар ажил хийх шаардлага гарсантай холбогдуулан байгууллагууд бүх үйл ажиллагаагаа цахимаар явуулах шаардлага гарч байна.

Коронавирус халдварт цар тахал 2 жил гаруй үргэлжилж байгаатай холбогдуулан манай орны хүрээнд бүх байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, сургалтуудыг цахимаар явуулж байна.

Дэлхийн эдийн засгийн форумын оролцогч, зохиолч Бернарда Марра цар тахлын дараах дэлхийн хамгийн эрэлттэй ур чадваруудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1.Дасан зохицох болон уян хатан байх

Төрийн болон хувийн хэвшлийн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулах

арга хэрэгсэл өөрчлөгдсөнөөр ажилтнууд түүнд дасан зохицох

2.Техникийн хэмнэлт

Коронавирусын цар тахлын нөлөөнөөс байгууллагуудын үйл ажиллагаа явуулах арга хэлбэр нь орчин үеийн техник технологид суурилсан цахим хэлбэрээр явагдах тул техникийн мэдлэгээ дээшлүүлэх.

3.Бүтээлч байдал, шинэ санаа

Коронавирусын цар тахлын нөлөөгөөр бүтээлч байдал, инновацад суурилсан үйл ажиллагааг илүүд үзэх болсон. Ажилтнуудаас бүтээлч, шинийг эрэлхийлэгч байдлыг шаардах болно.

4.Мэдээлэл ба мэдлэг

Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын эрин үед байгууллагуудын хувьд мэдээлэл хамгийн үнэт зүйл болно. Цар тахлын нөлөөгөөр дэлхийн хэмжээгээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд өөрсдийн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт шинэчлэлийг нэвтрүүлээд байна.

5.Шүүмж сэтгэлгээ

Коронавирусын цар тахлын нөлөөнөөс үүдсэн хямралын үед олон янзын эх сурвалжаас авсан мэдээлэл дундаас ажилтнууд шийдвэр гаргахдаа мэдээллийн үнэн бодитой эсэхийг давхар нягталж байх нь чухал гэдгийг онцолсон.

6.Дижитал ур чадвар

Кодчилал, веб маркетингийн ур чадваруудыг ажилтнуудаас шаардаж эхэлсэн.

¹Засгийн газрын мэдээ сонин 11 сарын 26, 2020

7.EQ сэтгэлгээ буюу сэтгэл зүйгээ удирдах

Сэтгэл хөдлөлөө ухамсарлах, илэрхийлэх, хянах чадвар хийгээд бусдын сэтгэл хөдлөлийг мэдэрч, удирдах чадвартай хүмүүс ирээдүйд илүү боломж эдэлнэ.

8.Насан туршдаа сурч боловсор

Өнөө үед үнэ цэнтэйд тооцогдож байсан мэдлэг нь 5 жилийн дараа 35% нь өөрчлөгдөх тухай Дэлхийн эдийн засгийн форумын үеэр онцолсон. Иймд насан туршдаа суралцах зайлшгүй шаардлагууд тулгарч байна.

Цахим сургалт нь орон зай, цаг хугацаанаас үл хамааран интернэтийн сүлжээ, программ хангамж ашиглан суралцах боломжийг хүн бүрд тэгш хангаж байдаг.

Дэлхийн хэмжээнд сургалтын арга технологи цахим шилжилт рүү эргэлт буцалтгүй шилжиж байгааг боловсролын салбарт явагдаж буй өөрчлөлт, шинэчлэлүүд нотолж байна.

2019 онд коронавирусын цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор Харварт, Окспорт, Стэндфорд, Бирмингем зэрэг дэлхийн топ

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын боловсрол түвшин /2023 он/
/График-1/



/Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны 2023 оны тайлан/

сургуулиудад цахим сургалтын хөтөлбөрөө баталж, хэрэгжүүлж эхэлсэн нь хичээлийг зөөврийн компьютероо ашиглан бие даан суралцах боломжийг бүрдүүлээд байна.

Хоёр.Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнд давтан болон мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж буй өнөөгийн байдал

Хил хамгаалах байгууллагад явагдаж буй сургалтыг цэргийн болон мэргэшүүлэх гэж ангилж болох бөгөөд өнөөдрийн байдлаар сургалтыг цэргийн удирдлагын нэгж болох Сургалтын хэлтэс, Хүний нөөцийн бодлого, зохицуулалтын газар тус тус хариуцан зохион байгуулж байна.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчийн мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг Хил хамгаалах ерөнхий газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар баталж, мөрдөн ажиллаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд явагдсан сургалтыг тоон судалгаагаар дүгнэвэл.

Мэргэжлийн сургалтын төрөл

/Хүснэгт-1/

Сургууль	Сургалтын чиглэл, мэргэжил	2017	2018	2019	2020
Дотоодын цэргийн академи, их, дээд сургууль					
Хууль сахиулахын их сургуульд	Үндсэн анги /өдрийн/	70	70	62	84
Удирдлагын академи	Стратеги-тактик, команд штаб	13	10	19	22
Үндэсний Батлан хамгаалах удирдлагын академи	Оператив-тактик, команд штаб	6		5	6
Гадаадын их дээд сургууль					
Оросын Холбооны Улс	Зэвсэгт хүчний академи		1		1
	Улсын хил хамгаалах салбарын удирдлага /Холбооны аюулгүй байдлын алба/	6	6	6	10
	Цэргийн төрөл мэргэжлийн академи /Батлан хамгаалах яам/	7	3	3	2
	Цэргийн академийн салбар их, дээд сургууль /Батлан хамгаалах яам/	3	3	3	2
	Калининград хотын Хилийн дээд сургууль	8	4	5	-
	Курган хотын Хилийн дээд сургууль	10	5	5	-
Бүгд Найрамдах Хятад Ард улс	Хөх хотын их сургууль	11	14	14	-
	Хятадын ардын чөлөөлөх армийн Цэргийн сургуулиудад	25	27	27	-
Бүгд Найрамдах Энэтхэг улс	Мэргэшүүлэх сургалт	30	20		-
Бүгд Найрамдах Солонгос улс	Хуурай замын цэргийн академи	1	1	1	1

Хил хамгаалах байгууллагын “Хүний нөөцийн дүрэм”-д заасны дагуу сургалтын хэрэгцээ, албан тушаалын нөөцийг нөхөн хангах, ойрын болон хэтийн төлөвлөгөөг үндэслэн байгууллагад шаардлагатай сургалтыг төлөвлөх, зохион байгуулах ажлыг мэргэжлийн газар хэлтэстэй хамтран

Хүний нөөцийн бодлого, зохицуулалтын газар зохион байгуулж явуулах үүрэг хүлээдэг¹.

Мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, гадаад, дотоодын цэргийн сургуульд суралцах хилчдийн хяналтын тоог жил бүр Хил хамгаалах ерөнхий газрын дарга баталдаг.

¹ Хил хамгаалах байгууллагын “Хүний нөөцийн дүрэм”-ийн ... дугаар заалт

Хил хамгаалах байгууллагын алба хаагчид сургалтад хамрагдах хүсэлтээ бичгээр уламжлан шийдвэрлүүлэх, эсвэл байгууллагаас санал гаргаж, бодлогоор мэргэжлийн болон бусад сургалтад хамруулж байна.

Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн сургалтын төрөл нь цэргийн, эрдмийн зэрэг олгох, төрөл мэргэжлийн, мэргэшүүлэх болон давтан гэсэн ангилалтай байна.

Цэргийн боловсролыг:

- Цэргийн тактикийн
- Цэргийн оперативын
- Цэргийн стратегийн

Цэргийн мэргэжлийн офицер, ахлагчийг гадаад, дотоодын цэргийн сургуульд, тусгай мэргэжлийн албан тушаалтныг гадаад, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудад гэрээгээр, удирдах ажилтныг гадаадын цэргийн академи, Батлан хамгаалах, Дотоод хэргийн их сургууль, бусад их дээд сургуулийн магистр, докторын сургалтаар тус тус сурган бэлтгэж байна.

Цэргийн албаны тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан цэргийн цол олгох журмын дагуу иргэний их дээд сургууль төгссөн иргэдийг офицер, ахлагчийн албан тушаалд томилоход Дотоод хэргийн их сургуулийн ахлагчийн сургуульд суралцуулж, цэргийн анхан шатны мэргэжил эзэмшүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дотоодын мэргэшүүлэх болон давтан сургалтад:

Удирдлагын академийн Төрийн албаны сургууль, Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны болон Ахлагчийн сургууль, хилийн 0151 дүгээр ангийн

Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, бусад боловсролын байгууллагаас зохион байгуулах сургалт хамаарна.

Хил хамгаалах байгууллагын тухайн жилийн зорилт, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга зүйн болон богино хугацааны мэргэшүүлэх сургалтыг бүсчилсэн, нэгдсэн хэлбэрээр зохион байгуулна.

Бүсчилсэн байдлаар буюу бүсийн сургалтын тулгуур анги /0165, 0168, 0132, 0243/ дугаар ангиудад;

Ажлын байран дээр ХХЕГ-аас батлагдсан төлөвлөгөөний дагуу ангиуд тус тус зохион байгуулан явуулж байна.

Гадаад хэлний сургалт:

Гадаад хэлний сургалтыг Хил хамгаалах байгууллагад зайлшгүй зохион байгуулах шаардлагатай гэж үзэн 2015 оноос хилийн ангиудад сургагч багш томилон зохион байгуулж эхэлсэн.

Анхан шатны сургалтыг ангиудад, ахисан болон дунд шатны сургалтыг Хил хамгаалах ерөнхий газарт, гүнзгий шатны сургалтыг мэргэжлийн сургалтуудад хамруулах зарчим баримтлан ажиллаж байна.

Албан хаагчдыг сургалт дамжаанд хамруулахад өөрийнх нь гаргасан хүсэлт, мэргэжлийн газар хэлтэс, анги, салбарын саналаар шийдвэрлэж байна.

Гадаад, дотоодын оператив түвшний их, дээд сургуульд элсэн суралцагчдад тавигдах шаардлага:

-Хил хамгаалах ерөнхий газрын офицер, хилийн анги, тусгай салбарын тасаг, албаны дарга болон түүнээс дээш албан тушаалд ажиллаж байгаа;

-Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “В” болон түүнээс дээш үнэлгээтэй дүгнэгдсэн;

-Бие бялдрын шалгуур үзүүлэлтийн стандартыг хангасан;

-Сахилгын болон ёс зүйн зөрчилгүй байх;

-Дэвшүүлэх албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн;

-Хилийн ангид 5-аас дээш жил үр бүтээлтэй ажилласан;

-30-36 хүртэл настай;

-Сургуулиас баталсан элсэлтийн журмын шаардлага хангасан байх;

-Суралцах улсын хэлний дунд болон түүнээс дээш түвшний мэдлэгтэй;

Дээрх суралцах хүсэлт гаргасан алба хаагчдыг сонгон шалгаруулалтад хамруулж, Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байна.

Хил хамгаалах алба нь мэргэжлийн бусад албанаас ялгарч байгаа гол онцлог нь 19 аймаг, 71 сумын нутаг дэвсгэрийг хамарсан Монгол Улсын 8252,6 км хилийн хэсгийг хамгаалах зорилгоор үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

Иймд хил хамгаалах байгууллагын алба хаагчид төв суурин

газраас алслагдмал хилийн анги, салбаруудад албан үүрэг гүйцэтгэдэг тул тэр бүр төв суурин газарт явагдах сургалт, дамжаанд хамрагдаж өөрсдийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх;

Тухайн алслагдсан хэсгээс ирж сурахад цаг хугацаа, хөрөнгө мөнгөө хэмнэх;

Байгууллагын алба хаагчдаас гадна тэдний гэр бүл, үр хүүхэд сурч хөгжих боломж хязгаарлагдмал байдаг зэрэг нөхцөлөөс шалтгаалан цахим сургалтын технологиудыг зайлшгүй нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Дүгнэлт, санал

“Хүн бүхэн өөрийн гэсэн гоц авьяастай. Харин загасыг модонд авирах чадвараар нь үнэлбэл тэр бүхий л амьдралынхаа турш өөрийгөө “чадваргүй амьтан” гэж бодох болно”
/Альберт Эйнштейн/

Монгол Улсын засгийн газрын 2019 оны 02 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг баталжээ. Өмнө нь дурдсан хууль тогтоомжийн шинэчлэл, ажлын хэрэгцээ шаардлагаар хил хамгаалах байгууллагын алба хаагчдад суралцах хэрэгцээ шаардлага байнга тавигдаж байх нь тодорхой юм.

Хилчдийн сургалтын хэрэгцээг хангах зорилгоор дараах байдлаар цахим сургалтыг байгууллагад зохион байгуулах саналыг дэвшүүлж байна.

1.Цэргийн алба хаагчдын зайлшгүй судлах зүйлсийн жагсаалт, хаанаас хайлт хийх арга замыг

тодорхой болгох, шаардлагатай бол цахим санг бүрдүүлэх.

2.Мэргэжлийн богино, дунд хугацааны цахим хөтөлбөр, сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах /Орон зай, цаг хугацааны хувьд ашигтай бөгөөд зардал буурна/

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Төрийн албаны тухай хууль 2017 он

Монгол Улсын хилийн тухай хууль 2017 он

Цэргийн албаны тухай хууль 2017 он

Монгол “Улсын цэргийн дүрмүүд” 2018 он

“Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр” Монгол Улсын засгийн газрын 2019 оны 02 дугаар тогтоол

3.Мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалтын программ нэгдсэн хангамжуудыг хөгжүүлэх.

4.Гадаад хэлний мэдлэгтэй алба хаагчдыг олон улсын цахим сургалтын хөтөлбөрүүдэд хамруулах, үр дүнг нийтэд сурталчлах.

“Зайны сургалтын үндэсний хөтөлбөр” Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 14 дүгээр тогтоол

“Цахим сургалтын өнөөгийн байдал, хүчин зүйлсийг судалсан нь” 2019

“Цахим сургалтад зориулсан бүтэц дээр суурилсан үнэлгээний загвар” 2014 Түдэвдагва Уранчимэг

Хил хамгаалах байгууллагын “Хүний нөөцийн дүрэм” ХХЕГ-ийн даргын 2022 оны ... дугаар тушаал

<https://Melearn.mn>

<https://ikon.mn/n/1ty5>